

## МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монголын ард түмэн “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм дээд зорилгыг Үндсэн хуульд тунхагласныг үндэслэн;

Монгол Улсын эдийн засгийн хөгжил шинэ үе шатанд гарч ардчиллыг гүнзгийрүүлэх, нийгмийн харилцааг ардчилсан ёсоор төлөвшүүлэх шаардлагыг харгалзан;

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичигт улс орны хөгжилд иргэн бүр оролцох, хувь нэмэр оруулах, манлайлах нөхцөлийг бий болгох, хууль, шударга ёс, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх уур амьсгал бүрэлдүүлж, иргэний нийгмийг хөгжүүлэн бэхжүүлэх, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг тууштай дэмжиж, иргэний нийгэм, төрийн харилцан түншлэлийг хангасан ардчилсан удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрийг хөгжүүлэх зорилтуудыг тодорхойлон тусгасныг баримтлан;

Төрийн оршин тогтнох суурь үндэс иргэдээс үүсвэртэй бөгөөд төрийн эрх мэдлийн эх сурвалж гагцхүү иргэдийн хүсэл зориг болохыг зөвшөөрч, төрөөс иргэний нийгмийг захирах бус, тэгш эрхтэйгээр түншлэн ажиллах зүй тогтлыг ухамсарлан;

Монгол Улсын иргэдийн идэвх санаачилга, авьяас билэг, хүч чадал шавхагдашгүй нөөц бөгөөд төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь ардчиллыг бэхжүүлэх, нийгмийн шударга ёс тогтоох, нийгмийн баялгийг бүтээх, улс орноо хөгжүүлэн эх орон, үндэсний тусгаар тогтнолоо мандуулан чиглүүлэгч хүч мөн гэж үзэж;

Монгол Улс дахь ардчиллын үнэт илэрхийлэл бөгөөд баталгаа, нийгмийн хөгжил дэвшлийн төлөөх төрийн түншлэгч хүчин бол чадварлаг, хүчирхэг, хараат бус иргэний нийгэм мөн гэдгийг хүлээн зөвшөөрч;

Монголын иргэний нийгэм нь хараат бус, бие даасан, олон янз байдал, эв санааны нэгдлийг эрхэмлэн үндсэн чиг үүргээ итгэл үнэмшил, идэвхи зүтгэлээрээ гүйцэтгэж ирсэн хориод жилийн туршлагыг бататган дэмжиж;

Улс төрийн тогтолцооны бүрдэл хэсэг болох төр, иргэн хоорондын харилцаа нь ардчилсан улс, нийгмийг хөгжүүлэх суурь харилцаа мөн бөгөөд иргэний нийгмийн талаар баримтлах төрийн бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээний үзэл санаа, дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн энэхүү харилцааг тэтгэн хөгжүүлэхэд чиглүүлж, үйл ажиллагаандаа ардчиллын хэм хэмжээг сахин мөрдөж нийгмийн эрх

ашгийг хамгаалах нь төр, иргэний нийгмийн нийтлэг зорилго мөн болохыг тодорхойлсоны үндсэн дээр энэхүү үзэл баримтлалыг боловсруулсан болно.

Энэхүү үзэл баримтлал нь иргэний нийгмийн тухай үндсэн ойлголт, ардчилсан төр, иргэний нийгмийн харилцаанд эрхэмлэх нийтлэг үнэт зүйлс, зарчмыг тодорхойлж төрөөс иргэний нийгмийн талаар хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээг тогтооно.

## **ХОЁР. ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ**

**2.1.** Иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо албан болон албан бус бүлэгт сайн дураараа нэгдэн, эсхүл дан ганцаараа улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор орон нутаг, салбар, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахыг иргэний нийгэм гэж ойлгоно.

Иргэний нийгмийг олон улсын хэмжээнд “ашгийн төлөө бус”, “сайн дурын”, “нийгмийн”, “буяны”, “гуравдахь хэвшил” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь иргэний нийгмийн олон төрөл хэлбэр бүхий байгууллагуудад нэгэн адил хамаарна.

**2.2.** Сүм хийд, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, улаан загалмайн байгууллага зэрэг эрх зүйн тусгай зохицуулалт бүхий байгууллага нь иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд иргэний нийгмийн байгууллагын үндсэн шинж чанарыг өөртөө нэгэн адил агуулна.

**2.3.** Иргэний нийгмийн байгууллагууд нь институтчиллын хөгжил, хараат бус байдал, нөлөөлөх чадварынхаа хувьд хоорондоо ялгарах боловч дараахь нийтлэг шинж чанарыг агуулна:

**2.3.1.** нийтийн ашиг тусад чиглэсэн зорилготой, ашгийн төлөө бус буюу олсон аливаа орлогоосоо ашиг хуваарилдаггүй, нийгэмд буюу гишүүддээ үйлчилдэг, тодорхой зохион байгуулалт, өөрийн удирдлагын бүтэц бүхий, төрөөс хараат бус зэрэг үндсэн шинж чанарыг агуулдгаас гадна үйл ажиллагаандаа сайн дурын оролцоо, дэмжлэгийг зохих хэмжээгээр шингээсэн;

**2.3.2.** иргэдийн эрх ашиг, хэрэгцээг төлөөлөн илэрхийлэх, хүний эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг хүлээдэг;

**2.3.3.** төрийн аливаа дарамт, шахалт, нөлөөнөөс ангид байх бөгөөд энэ нь ардчиллыг гүнзгийрүүлэх, нийтлэг эрх ашиг, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, нийгмийн өөрчлөлтийг нэхэн шаардах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа шударга, үр дүнтэй явуулах гол нөхцөл болдог.

**2.4.** Иргэний нийгмийн байгууллага, албан болон албан бус бүлгүүдийг төлөвшүүлэн бэхжүүлэх нь иргэний нийгмийн хөгжлийг хангах үндсэн арга зам мөн.

## **ГУРАВ. ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС, ЗАРЧИМ**

Нийгмийн эрх ашгийг хамгаалах эрхэм зорилгын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор ардчилсан төр, иргэний нийгмийн байгууллага нь үйл ажиллагаандаа дараахь нийтлэг үнэт зүйлс, зарчмыг удирдлага болгоно.

### **3.1. Нийтлэг үнэт зүйлс**

#### **3.1.1. Эрүүл, аюулгүй орчин**

Өнөөгийн болон ирээдүйн үеийнхний оршин тогтнох эрх, түүний дотор эрүүл, аюулгүй орчинд аж төрөх, хөгжиж дэвших эрх хэрэгжих нь байгаль орчин, хүрээлэн байгаа орчны даацыг нарийн харгалзсан тогтвортой хөгжлийн замыг сонгох эсэхээс хамаарна.

Байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд экологийн тогтвортой байдал, хүний хөгжил, түүнчлэн, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн буюу өртөх эрсдэл бүхий бүлгүүдийн оролцоог хангахуйц чадамж, шинэлэг шийдлүүд шаардлагатай бөгөөд эдгээр чадамж, шийдэл нь төрийн цэгцтэй бодлого, үйл ажиллагаа, иргэний нийгмийн идэвхтэй оролцоогоор тодорхойлогдоно.

#### **3.1.2. Хүний эрх, үндсэн эрх чөлөө**

Төр, иргэний нийгмийн үйл ажиллагаа, хоорондын харилцаа, хамтын ажиллагааны чанар, үр өгөөжийн гол шалгуур нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөний бодит хэрэгжилт байна.

Монголын төр, иргэний нийгмийн байгууллага бүхий л бодлого, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагыг баримталснаар тэгш бус байдал, эмзэг, өртөмтгий байдал, нийгмийн гадуурхал, алагчлал зэрэг ядуурлыг бий болгодог тогтолцооны чанартай хүчин зүйлсийг арилгаж, хүний улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, иргэний эрхийг хангана.

#### **3.1.3. Эрх зүйт ёс**

Эрх зүйт ёс нь хараат бус шүүх, авлигаас ангид хууль сахиулах байгууллага, хүний эрхэд суурилсан тэгш, шударгаар хэрэгждэг хууль, хүний эрх, үндсэн эрх чөлөө, түүний дотор цөөнхийн эрхийг бүрэн, аливаа ялгаварлалгүйгээр хамгаалахад оршино.

#### **3.1.4. Олон янз байдал, төлөөлөл**

Яс үндэс, угсаа гарал, хэл соёл, нас, хүйс, бие махбодийн чадамж, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, эдгээрээс үүдэлтэй

эрх ашиг, хэрэгцээ, амьдралын хэв маяг зэрэг шинж чанараараа хувь хүн, бүл хамтлаг онцлог, ялгаатай байдаг нь нийгмийн баялаг мөн.

Төр, иргэний нийгэм нь үйл ажиллагаандаа энэхүү олон янз байдал, нийгмийн бүлгүүдийн эрх ашгийг тусгаж, хүн бүрийн санаа бодлыг сонсож харгалзах явдал ардчилсан хүмүүнлэг нийгмийн үндсэн шинж мөн.

Өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй, нийгмийн эмзэг бүлэг, иргэдэд туслах шинэлэг арга хэлбэрийг эрэлхийлэн нэвтрүүлдэг иргэний нийгмийн байгууллагуудын олон талт үйл ажиллагаа, тэдгээрийн онцлог байдал нь иргэний нийгмийн давуу тал мөн.

### **3.1.5. Хүлээцтэй хандлага**

Хүлээцтэй хандлага нь бусдын эрх, үндсэн эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх үзэлд суурилсан идэвхтэй байр суурь юм.

Хувь хүн, хамт олон, төр нь хүлээцтэй хандлагыг тус тус үйл ажиллагаанд хэвшүүлэх нь ардчилал, нийгмийн эв эеийн оршин тогтнох чухал нөхцөл мөн.

Хүлээцтэй хандах нь хувь хүн, нийгмийн бүлгийг бусдаас ялгаатай шинжийнх нь улмаас дарамтлах, хүчирхийлэх үйлдэлд буулт хийх, түүнийг өөгшүүлэхийн аливаа утга өөртөө агуулахгүй бөгөөд бусдын нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдлийг хаацайлах үндэслэл болохгүй.

### **3.1.6. Нийгмийн эв эе, шударга ёс**

Ардчилал, нийгмийн эв эе оршин тогтнох үндэс бол хүчирхэг иргэний нийгмээс үүдэлтэй нийгмийн хэлцэл, эрх ашгийн өргөн төлөөлөл юм.

Иргэний нийгмийн байгууллагууд иргэдийн хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлж нийгмийн амьдралыг хамтын ажиллагаа, эв санааны нэгдэлд суурилуулж өгдөг.

Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бий болж төрийн бодлогод нийгмийн оролцогчдын олон талт сонирхол тусгалаа олсноор нийгэмд өргөн хүрээний зөвшилцөл бий болж шударга ёс тогтоно.

### **3.1.7. Хүмүүнлэг үйлс**

Хүмүүнлэг үйлс (филантропи) нь иргэн хүн нийгмийн сайн сайхны төлөө, иргэдийн амьжиргаа, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор өөрийн өмч хөрөнгөөс буцалтгүй тусламж олгох, мөн өөрөө буюу байгууллагаар дамжуулан мэдлэг, ур чадвар, цаг зав, хөдөлмөрөө үнэ төлбөргүй хандивласан сайн дурын үйл ажиллагаа юм.

## **3.2. Үнэт зүйлсийг бататгах зарчим**

### **3.2.1. Тэгш боломжийг хангах**

Төр, иргэний нийгмийн байгууллага хүнийг нас, хүйс, яс үндэс, угсаа гарал, бие махбодийн чадамж, бэлгийн чиг баримжаа, шашны болон улс төрийн үзэл бодол зэрэг шинжээр нь үгүйсгэх, ялгаварлах, хязгаарлахгүйгээр шийдвэр гаргах, хөгжлийн үйл явцад оролцох, үр шимээс нь хүртэх боломжийг бүрдүүлнэ.

### **3.2.2. Харилцан хүндэтгэх**

Төр, иргэний нийгэм нь улс орныхоо хөгжлийг хангах үйл хэрэгт тус тусын ялгаатай бөгөөд харилцан шүтэлцээтэй үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээдгээ хүлээн зөвшөөрч хоорондоо болон холбогдох бусад талуудтай тэгш эрхтэй, харилцан хүндэтгэлтэйгээр хамтран ажиллана.

Аливаа хүчирхийлэл, түрэмгийллээс ангид байж, хэнийг ч үл ялгаварлан бүгдэд хүндэтгэлтэй, тэгш хандана.

### **3.2.3. Олон янз байдал, төлөөллийг хөхиүлэн дэмжих**

Хүмүүсийн эрэлт, хэрэгцээ нь нийгмийн байдал, газар зүйн байршлаас шалтгаалан ялгаатай байхаас гадна байнга өөрчлөгдөх тул тэдний эрх ашгийг төлөөлөн илэрхийлэх, тэдэнд үйлчлэх иргэний нийгмийн байгууллага, бүлгүүд шинээр бий болж ажил үйлчилгээ гүйцэтгэх, хамтран ажиллах төрөл, хэлбэр нэмэгдэхийг дэмжинэ.

Иргэний нийгмийн олон салбар, төлөөллийг, ялангуяа үндэстэн, хэл, бэлгийн чиг баримжааны цөөнх болон үзэл бодол, итгэл үнэмшил, нас, хүйс, бие махбодийн чадамж, газар зүйн байршил, шилжилт хөдөлгөөн зэргийн улмаас эрхээ эдлэх боломж нь хязгаарлагдсан, эрх нь зөрчигдсөн, анхаарлын гадна үлдсэн болон эрсдэлт, эмзэг бүлгүүдийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамруулахыг хоёр тал дэмжинэ.

### **3.2.4. Иргэний нийгмийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг эрхэмлэн дээдлэх**

Төрийн байгууллага нь иргэний нийгмийн байгууллагатай тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран түүний хараат бус байдал, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хүндэтгэнэ.

Иргэний нийгмийн байгууллага нь төрийн байгууллагатай тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран хэлэлцэж байгаа асуудалд зарчмын байр сууринаас хандаж, хараат бус байдлаа эрхэмлэн дээдэлнэ.

Иргэн болон иргэдийн байгууллага, бүлгүүд хэрэгжүүлэх зорилго, зорилтоо өөрсдөө тодорхойлж үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн хүрээнд явуулах эрхийг төр хүндэтгэж иргэний нийгмийн байгууллага улс төрийн нөлөөллөөс ангид явуулах орчныг бүрдүүлнэ.

### **3.2.5. Бодлогын хэлцэл явуулах**

Төр, иргэний нийгэм хамтран ажиллах, зөвлөлдөх байнгын арга механизмыг тухайн орон нутаг, бүс, үндэсний түвшинд төлөвшүүлэн, хөгжлийн стратеги тодорхойлох үйл ажиллагааны нийгмийн суурийг өргөжүүлж, төрийн бодлого, шийдвэрийг чанаржуулан итгэлцлийг бий болгоно.

### **3.2.6. Бодит, тэгш оролцоог хангах**

Идэвхтэй оролцоо нь иргэд нийгмийн нөөц, баялгаас тэгш хүртэх, хөгжих илүү боломжийг бий болгодог тул иргэдийг, нэн ялангуяа хэл, яс үндэс, угсаа гарал, нас, хүйс, орлого, газар зүйн байршил зэргээс хамаарч эрх ашиг нь хөндөгдсөн бүлгүүдийг төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан үнэлэх ажилд татан оролцуулна.

Оролцогч талуудыг тухайн асуудалтай холбоотой мэдээлэл авах, саналаа бэлтгэх, түүнийгээ хүргэх бодитой бололцоогоор хангах үүргийг төр, иргэний нийгмийн байгууллага нэгэн адил хүлээнэ.

### **3.2.7. Ил тод байх**

Ил тод байдал, мэдээлэл нээлттэй байх нь сайн засаглалын суурь зарчим тул иргэн төрийн хэрэгт мэдээлэлтэй, мэдлэгтэй оролцох бүхий л боломжийг төрийн байгууллага, түүний албан тушаалтан бүх шатанд хангана.

Ил тод байдлын зарчмыг хэрэгжүүлэх нь иргэний нийгмийн байгууллагын үйлчлүүлэгч, сайн дурын болон орон тооны ажилтан, гуравдагч тал, байгууллагын дотоод ардчилалд аливаа сөрөг үр дагавар учруулах ёсгүй.

### **3.2.8. Хариуцлага хүлээх**

Төр, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр татвар төлөгч иргэдийн хөрөнгө тул төр, иргэний нийгэм нь төлөвлөлт, зарцуулалт, үр дүнг нийтэд нээлттэй, ил тод байлгах, хариуцлага хүлээх, тооцох тогтолцоотой байна.

Төр болон иргэний нийгмийн байгууллага нь гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээнийхээ чанарын төлөө олон нийт, төлөөлж буй иргэд, бүл хамтлагийн өмнө хариуцлага хүлээх зарчмыг чанд сахина.

Төрөөс үзүүлэх үйлчилгээний чанарын үзүүлэлт хуулиар тогтоогдож иргэний нийгмийн хараа хяналт түүнийг хангахад чухал үүрэгтэй. Иргэний нийгмийн байгууллага нь үйл ажиллагааныхаа эцсийн үр дүн, чанарыг зорилтот бүлгийнхээ хүлээлтээр тодорхойлдог онцлогийг төрийн болон хөндлөнгийн үнэлгээний аргазүйд харгалзана.

### **3.2.9. Үр ашигтай байх**

Хүний болон эдийн засаг, санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг үрэлгэн бус, авлигаас ангид, ирээдүйн үеийнхний эрх ашгийг хохироохгүйгээр үр өгөөжтэй ашиглана.

Бодлого, үйл ажиллагааны тууштай, харилцан уялдаатай чанарыг хангана.

### **3.2.10. Авлигаас ангид байх**

Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь гэрээ, төслөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэх, төрөөс санхүүжилт авах иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулахдаа сонирхогч талуудтай ашиг сонирхлын зөрчилтэй, авлига дагуулж болзошгүй аливаа харилцаанд орохгүй.

Иргэний нийгмийн байгууллага нь өөрийн мөн чанар болох хараат бус байдлаа хамгаалах үүднээс энэхүү харилцаанд өртөхөөс сэргийлнэ.

Төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд өөрийн удирдлага, үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг чанд сахина.

## **ДӨРӨВ. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНЭТ ЗҮЙЛС, ЗАРЧМЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭ**

Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын зорилго нь иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагын чадамжийг дээшлүүлэх, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох замаар нийгмийн ашиг сонирхолыг хамгаалахад оршино.

**4.1.** Энэхүү бодлого нь нийгмийн капитал, нийгмийн шинэтгэл болон нийгмийн эдийн засгийн тухай ойлголтод тулгуурлан, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж иргэний нийгмийн байгууллагын үндсэн чиг үүргийг бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг хангана.

#### **4.1.1. Нийгмийн капитал (хөрөнгө нөөц)-ын тухай ойлголт**

Нийгмийн капитал бол нэг талаас нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хүмүүсийг холбон нэгтгэдэг хэм хэмжээ, үнэт зүйлс, хандлага, итгэл үнэмшил, нөгөө талаас, нийгмийн зохион байгуулалтын албан ба албан бус бүтэц, холбоо харилцаанаас тогтох материаллаг бус хөрөнгө нөөц юм.

Аливаа хамт олон тодорхой хэмжээний нийгмийн капиталтай байдаг бөгөөд энэ хөрөнгө нөөц их байх тусам хамт олон нийтлэг ашиг сонирхлоо хангах, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх чадавхи нь нэмэгддэг.

Нийгмийн капиталыг бүрдүүлэх, арвижуулах, дайчлах үүргийг гол төлөв иргэний нийгмийн байгууллага, ялангуяа анхан шатны бүл хамтлаг гүйцэтгэдэг тул нийгмийн капитал арвин байх эсэх нь иргэний нийгмийн хөгжил, чадамжаас шууд хамаарна.

#### **4.1.2. Нийгмийн шинэтгэлийн тухай ойлголт**

Нийгмийн шинэтгэл гэж хувь хүн, хамт олны нийгэм, соёл, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн аливаа ажил, бараа, үйлчилгээг шинэлэг буюу сайжруулсан арга хэлбэрээр хэрэгжүүлэхийг ойлгоно.

Иргэний нийгмийн байгууллага нь нийгмийн шинэтгэлийг санаачлах, хамт олны түвшинд түгээн дэлгэрүүлж манлайлах үүргийг биелүүлдэг.

Хүнд хүрч ажиллах талаар хуримтлуулсан мэдлэг туршлага, үйл ажиллагааны уян хатан, шуурхай байдал, мэдрэмжтэй чанар, бүтээлч сэтгэлгээ, боломжийг гярхай харж үр дүнтэй ашиглах арга ухаан, асуудалд цогц хандах хандлага зэрэг иргэний нийгмийн байгууллагын онцлог шинж чанар нь нийгмээрээ суралцаж, нийгэм-эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд гол үүрэгтэй. Иргэний нийгмийн үйл ажиллагаа өрнөхийн хирээр нийгмийн шинэтгэл хийх боломж нэмэгдэнэ.

#### **4.1.3. Нийгмийн эдийн засгийн тухай ойлголт**

Нийгмийн эдийн засаг гэж аливаа улс төр, нийгэм-эдийн засаг, соёл, газар зүйн байршил зэрэг шинжээр гадуурхагдсан бүлгийг хамгаалах, хөгжүүлэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөхцлөө сайжруулахад чиглэсэн, гол төлөв орон нутгийн бүлийн түвшинд явуулж буй ашгийн төлөө бус аж ахуйн үйл ажиллагааг нэрлэдэг.



Нийгмийн эдийн засгийн байгууллага нь аж ахуйн нэгжийн нэгэн адил бараа, үйлчилгээгээ зах зээл дээр борлуулдаг ч олсон ашиг, орлогоосоо ашиг хуваарилдаггүй, бүгдийг нь нийгмийн болон хамт олны ашиг тусын тулд ил тод зарцуулдаг.

Нийгмийн эдийн засгийн чиг баримжаатай иргэний нийгмийн байгууллага нь соёлын уламжлал, зан үйлийн үнэт зүйлсийг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, мэргэжил олгох, бүл хамтлагийн дунд өөрийн дэмжлэгийн бүтэц бий болгох, орчноо тохижуулах, байгаль орчныг хамгаалах, эрх ашиг нь хөндөгдсөн бүлгүүдийг чадавхижуулан идэвхжүүлэх зэрэг хамт олонд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, улмаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмждэг уян хатан, тогтвортой арга механизм юм.

## **4.2. Төрийн бодлогын стратегийн чиглэлүүд**

Иргэний нийгмийн хөгжлийг дэмжихэд баримтлах төрийн бодлогын хүрээнд дараахь стратегийн чиглэлүүдийг тодорхойлж байна:

- Ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.

### **4.2.1. Ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх**

Ардчилсан улс төрийн соёл гэдэг нь сайн нийгэм, сайн засаглалын талаархи иргэдийн нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, дадал, хандлагыг хэлнэ.

Улс төрийн соёл нь тодорхой асуудлаар иргэд ижил санал бодолтой байх бус, нийгмийн гишүүн бүрийн эрх, үүрэг болон улс төрийн үйл явцад оролцох хэм хэмжээний тухай нэг мөр ойлголттой байх явдал юм.

**4.2.1.1.** Монгол Улсын хууль тогтоомжийг хүний эрхийн талаас хянан үнэлж, Үндсэн хуульд заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөний бодит хэрэгжилтийг бусад хууль тогтоомжоор баталгаажуулж, иргэний нийгмийн байгууллагаас хүний эрхийг хамгаалж, төрийн байгууллага, түүний удирдах ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих, нөлөөлөх үндсэн чиг үүргээ аливаа саад, дарамтгүй гүйцэтгэх бололцоог хангана.

**4.2.1.2.** Төрийн алба, түүний дотор хууль сахиулах, шүүх засаглалын байгууллагын албан хаагчдын иргэний нийгмийн талаархи зохих мэдлэг, зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлж, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах туршлага, чадавхийг бүрдүүлнэ.

**4.2.1.3.** Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны нийгмийн үнэлэмжийг дээшлүүлж иргэний нийгмийн байгууллагын ажилтан, идэвхтэн, сайн дурын ажилтныг мэргэшсэн ажиллах хүчний чухал нөөц гэж үзнэ.

**4.2.1.4.** Иргэд үнэн зөв мэдээлэл авах эрх, эрх чөлөөг дээдэлж, бодит мэдээллээр хангах чадавхи бүхий хараат бус, мэргэжлийн, хариуцлагатай

хэвлэл мэдээллийг бий болгоход чиглэсэн улс төр, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

**4.2.1.5.** Ардчилсан үзэлтэй, ёс суртахуунтай, бүтээлч сэтгэлгээтэй, өрсөлдөх чадвартай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор бүх шатны албан болон албан бус боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрх, иргэний боловсролын агуулгыг тусган шинэчилж, үүнд чиглэсэн иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

#### **4.2.2. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх**

Иргэдийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих шйл ажиллагаанд татан оролцуулах нь төрөөс ухамсартайгаар хийж байгаа эрх мэдлийн дахин хуваарилалт мөн бөгөөд энэ нь иргэд аж байдалд нь шууд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд өөрсдөө оролцох эрхээ бодитой эдлэх чухал нөхцөл юм.

Иргэний нийгмийн байгууллага нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад иргэдийн оролцоог хангах гол механизм болно.

**4.2.2.1.** Хуулийн болон бодлогын баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх явдлыг хэвшүүлж, хууль тогтоомжид иргэдийн саналаар нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг боловсруулж хуульчилна.

**4.2.2.2.** Орон нутаг, бүс, үндэсний түвшинд хөгжлийн асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэний нийгмийг оролцуулах арга механизмыг боловсронгуй болгож, улмаар ийм үйл ажиллагааг иргэний нийгмийн байгууллага санаачлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.

**4.2.2.3.** Бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд иргэний нийгмийн төлөөлөл бүхий бодит оролцоог хангах нийтлэг журмыг хууль тогтоох байгууллага, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нэг мөр мөрдөхөөр боловсруулж батална.

**4.2.2.4.** Иргэний нийгмийн байгууллага зохион байгуулалтынхаа бүх түвшинд өөрийн гишүүд, төлөөлж буй зорилтот бүлэг, иргэдийн бодит оролцоог хангах, төлөөлөх эрхээ баталгаажуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

#### **4.2.3. Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх**

Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь хоёр талын хүсэл зориг, ажил хэрэгч хандлага, байгууламжийн чадавхийг шаардана.

#### **4.2.3.1. Иргэний нийгмийн байгууллагын талаархи бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох**

Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг Монголын иргэний нийгмийн хөгжлийн чиг хандлага болон олон улсын хэм хэмжээ, аргазүй, туршлагад нийцүүлэн шинэчлэнэ:

а\ Нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа, иргэний нийгмийн байгууллагын төрөл хэлбэрийн тодорхойлолт, ангиллыг олон улсын арга зүйд нийцүүлэн хуульчилна.

б\ Иргэний нийгмийн байгууллагын бүртгэл, тайлагналтын журмыг уян хатан болгож, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ, хүчин чадал зэрэг онцлогийг харгалзан үйл ажиллагаанд нь хэт ачаалал, зардал учруулахгүйгээр боловсруулж тогтооно. Бүртгэхээс татгалзах үндэслэлийг нарийн тогтоож, татгалзсан шалтгааныг бичгээр тайлбарлах журам нэвтрүүлнэ.

в\ Иргэний нийгмийн байгууллагыг төрөөс магадлан итгэмжлэх журмыг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хуулиар тогтоосон чанарын стандарт бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа иргэний нийгмийн байгууллагын хувьд хэрэглэнэ.

Иргэний нийгмийн байгууллагууд зөвшилцлийн үндсэн дээр боловсруулан дагаж мөрдөж байгаа ёс зүйн хэм хэмжээг төр хүлээн зөвшөөрч иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагаандаа хэрэглэж болно.

Иргэний нийгмийн байгууллагын нийтийн эрх ашгийг хамгаалах асуудлаар бусдыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг бодлого, хуулиар баталгаажуулна.

Иргэний нийгмийн байгууллагын хяналтын эрхийг хуулиар баталгаажуулж, түүний гүйцэтгэсэн хяналтын үр дүнг эрх зүйн үр дагавартай болгоно.

#### **4.2.3.2. Иргэний нийгмийн байгууллагын тогтвортой хөгжлийг төрөөс дэмжих**

Тууштай зорилго, зохистой удирдлага, санхүүгийн олон тулгуурт эх үүсвэртэй байх нь иргэний нийгмийн байгууллагын тогтвортой байдлыг тодорхойлно.

Иргэд болон иргэний нийгмийн байгууллагаас нийтийн эрх ашгийн төлөө явуулж байгаа үйл ажиллагааг чанаржуулах, хүмүүнлэг, сайн дурын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, иргэний нийгмийн байгууллагын чадамж, чадавхийг нэмэгдүүлэхийн тулд төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх тууштай бодлого баримтална.

Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь шууд болон шууд бус хэлбэртэй байна. Шууд дэмжлэг нь төрөөс иргэний нийгмийн байгууллагад

олгож байгаа төсөл болон бусад хэлбэрийн мөнгөн буюу мөнгөн бус тэтгэлэг юм.

Шууд бус дэмжлэг нь иргэний нийгмийн байгууллага болон иргэд, хувийн хэвшлийн байгууллагаас нийтэд ашиг тустай үйл ажиллагаа явуулах, ивээн тэтгэхийг хөхиүлэн дэмжсэн татварын зохицуулалт болно.

Иргэний нийгмийн байгууллагын нийтэд ашиг тустай үйл ажиллагааг идэвхижүүлэх, иргэн болон хувийн хэвшлийн нийгмийн хариуцлага, ухамсрыг төлөвшүүлэх, улмаар хүмүүсийн харилцан туслалцаа, хамтын ажиллагаанд суурилсан нийгмийн эв эеийг төлөвшүүлэх зорилгоор иргэний нийгмийн байгууллага болон ивээн тэтгэгч иргэн, аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зарчмыг төрийн бодлого, хуулиар хамгаална.

Иргэний нийгмийн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийг хангах үүднээс төрийн шууд болон шууд бус дэмжлэгийн төрөл хэлбэрийг өөрийн орны санхүү-эдийн засгийн чадавхи болон олон улсын жишигт нийцүүлэн тууштай нэмэгдүүлнэ.

Нийгмийн эдийн засгийг хөхиүлэн дэмжихийн тулд шударга өрсөлдөөний зарчимд суурилсан зах зээлийн харилцааг хөгжүүлнэ.

Орлого олж үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, нийгэм, байгаль орчин, соёлын үнэт зүйлс бий болгох зорилготой иргэний нийгмийн байгууллагын ашгийн төлөө бус аж ахуйн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны чанар, үр өгөөж, урт хугацааны төлөвлөлт хийх чадавхийг хангах үүднээс санхүүжилтийг хангалттай хэмжээ, хугацаатайгаар олгоно.

Төрөөс болон бусад эх үүсвэрээс иргэний нийгмийн байгууллагад олгосон санхүүжилтийн зохих хэсгийг тухайн байгууллагын хөгжлийн хэрэгцээг хангах зорилгоор захиргааны зардалд зарцуулах зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Төрийн санхүүжилтийг иргэний нийгмийн байгууллагуудад хуваарилах үйл ажиллагааг нийтлэг журмын дагуу, ил тод, орон нутагт хүртээмжтэй байдлаар зохион байгуулж явуулна.

Иргэний нийгмийн талаархи онол, арга зүйг хөгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжинэ.

Иргэний нийгмийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг төлөвшүүлэх зорилгоор иргэний нийгмийн байгууллагуудын цахим мэдээллийн сүлжээ байгуулах, тогтвортой үйл ажиллагааг нь хангахад туслана.

Иргэний нийгмийн байгууллагууд нь иргэний нийгэмд итгэх олон нийтийн итгэлийг бататгах, төртэй болон өөр хоорондоо явуулах хамтын

ажиллагаа, дотоод үйл ажиллагаандаа ардчилал, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих зорилготой өөрийн зохицуулалтын арга механизмыг боловсронгуй болгохыг хөхиүлэн дэмжинэ.

Хууль тогтоомж, иргэний нийгмийн байгууллагын хуульд заасан эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих төрийн чадавхийг нэмэгдүүлж боловсронгуй болгоно.

## **ТАВ. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО**

**5.1. Энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг чанд баримтална:**

**5.1.1.** Төрийн болон иргэний нийгмийн байгууллага үлгэр дууриал үзүүлж, санаачлагатай, хариуцлагатай, тууштай үйл ажиллагаагаараа манлайлан ажиллах;

**5.1.2.** Холбогдох бүх талуудын оролцоо, хамтын ажиллагааг бүхий л түвшинд хангах;

**5.1.3.** Үйл ажиллагааг харилцан зөвшилцсөн, бодит мэдээлэл, судалгаанд тулгуурласан, өртөг зардлыг нь тооцсон төлөвлөлтийн үндсэн дээр хэрэгжүүлэх;

**5.1.4.** Иргэний нийгмийн байгууллагын оролцоог мэргэшил, төлөөллийн зарчмаар тодорхойлох;

**5.1.5.** Хэрэгжилтэд хамтын хяналтын тогтолцоог бий болгож, үйл явц, үр дүнг олон нийтэд ил тод, тогтмол мэдээлэх;

**5.1.6.** Энэхүү үзэл баримтлал болон түүнтэй нийцүүлэн гаргасан төрийн бодлого, шийдвэрийг эс биелүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтантай хариуцлага тооцох.

### **5.2. Хэрэгжүүлэх механизм**

**5.2.1.** Иргэний нийгмийн асуудал эрхэлсэн чиг үүргийг хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын хүрээнд бий болгож төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн бүтцийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргаа болон өөрөө удирдах байгууллагад бүрдүүлнэ.

**5.2.2.** Энэхүү үзэл баримтлалд тулгуурласан төрийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэний нийгмийг төлөөлж төрийн байгууллагатай үндэсний болон орон нутгийн түвшинд хамтран ажиллах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийг иргэний нийгмийн байгууллагууд дундаасаа нээлттэй, ил тод, өргөн оролцооны зарчмаар үүсгэн байгуулна.

**5.2.3.** Иргэний нийгмийн хөгжил, төр болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааг урт хугацааны хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.

**5.2.4.** Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоо бүрдүүлнэ.

## **ЗУРГАА. БУСАД**

### **6.1. Үзэл баримтлалыг боловсруулж баталсан нь**

Энэхүү үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "...төрийн удирдлагад иргэний нийгмийн оролцоог хангах зорилгоор иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчилж, төрийн байгууллагад хяналт тавих, нөлөө үзүүлэх, дэмжлэг авах, ажил гүйцэтгэх зэрэг төр-иргэний нийгмийн бүх талын түншлэл, төр-иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлж, хөгжүүлэх", "...төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох" зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 17 дугаар захирамжаар байгуулсан төр, иргэний нийгмийн төлөөлөл бүхий ажлын хэсэг боловсруулж, төслийг нийслэлийн иргэний нийгмийн 70 гаруй байгууллага, 21 аймгийн төр, иргэний нийгмийн байгууллагуудаар тус тус хэлэлцүүлж, улмаар 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн төр, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон бүсчилсэн видео хуралданаар шүүлгэж, нийтдээ 40 гаруй удаагийн хэлэлцүүлгийг өргөн хүрээтэйгээр зохион байгуулсны эцэст Иргэний нийгмийн үндэсний чуулганы 500 гаруй төлөөлөгч 2012 оны 3 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд хянан хэлэлцэж Монгол Улсын Засгийн газарт уламжилсан бөгөөд Монгол Улсад дагаж мөрдөж буй зохих хууль тогтоомжийн журмын дагуу шат дараалан өргөн барьж УИХ-аас баталсан бодлогын баримт бичиг болно.

### **6.2. Үзэл баримтлалын үнэт зүйлс, зарчмыг эрхэмлэн дээдлэх**

Төр, иргэний нийгэм нь энэхүү үзэл баримтлалд тунхагласан сайн засаглалын үнэт зүйлс, зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон чанд сахиж, гуйвалтгүй мөрдөнө.

### **6.3. Үзэл баримтлалын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

Үзэл баримтлалд иргэний нийгмийн хөгжил дэвшлийг цаашид гүнзгийрүүлэхэд чиглэсэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт хийж болно. Энэхүү ажиллагаанд төр, иргэний нийгэм хоорондоо зөвшилцөх, хоёр талын тэгш оролцоог хангах, ил тод байх зарчмыг баримтална.